



## ӨМНӨГОВЬ АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТИН ГАЗАР

Нутгийн удирдлагын ордон 304 тоот, 3 дугаар баг,  
Даланзадгад сум, Өмнөговь аймаг, 46083  
Утас: (976) 7053 3539, Цахим хуудас: [www.audit.mn](http://www.audit.mn)  
Цахим шуудан: umnugovi@audit.gov.mn

2024.08.06 № 573  
танай \_\_\_\_\_ -ны № \_\_\_\_\_ -т

## СЭВРЭЙ СУМЫН СОНГУУЛИЙН ХОРООНД

Г Сонгуулийн мөрийн хөтөлбөр хуульд  
заасан шаардлагад нийцсэн талаарх  
дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйл, Аймаг, нийслэл, сум, дүүргийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын сонгуулийн тухай хуулийн 37 дугаар зүйлийн 37.5, Хөгжлийн бодлого, төлөвлөлт, түүний удирдлагын тухай хуулийн 5.4-т заасан бүрэн эрхийн хүрээнд 2024 оны Сэврэй сумын иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын ээлжит сонгуульд оролцох "Ардчилсан нам"-ын сонгуулийн мөрийн хөтөлбөрийг хянаж, дүгнэлт гаргалаа.

### Үүрэг хариуцлагын талаарх мэдээлэл

2024 оны Аймаг, нийслэл, сум, дүүргийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын ээлжит сонгуульд оролцох нам, эвсэл болон бие даан нэр дэвшигч нь сонгуулийн мөрийн хөтөлбөрөө Аймаг, нийслэл, сум, дүүргийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын ээлжит сонгуулийн тухай хууль, Төсвийн тогтвортой байдлын тухай хууль, Хөгжлийн бодлого, төлөвлөлт, түүний удирдлагын тухай хууль болон Монгол Улсын Үндэсний аюулгүй байдлын үзэл баримтлал, "Алсын хараа-2050" Монгол Улсын урт хугацааны хөгжлийн бодлого, УИХ-аас баталсан хөгжлийн бодлого, төлөвлөлтийн баримт бичигт нийцүүлэн боловсруулж, санхүүгийн тодорхой эх үүсвэр шаардсан зорилт, арга хэмжээг хэрэгжүүлэхэд шаардагдах зардлын талаарх тооцоо, судалгааг гарган хуульд заасны дагуу дүгнэлт гаргуулах үүрэг хүлээнэ.

### Сонгуулийн мөрийн хөтөлбөрийн дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага нь 2024 оны Аймаг, нийслэл, сум, дүүргийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын ээлжит сонгуульд оролцох нам, эвсэл болон бие даан нэр дэвшигчийн сонгуулийн мөрийн хөтөлбөрийг хянан үзэхдээ Төрийн аудит MNS 6817 - 1 : 2020 Төрийн аудит. Тулгуур зарчим, MNS 6817 - 6 : 2020 Төрийн аудит. Нийцлийн аудитын зарчим, MNS 6817 - 8 : 2020 Төрийн аудит. Нийцлийн аудит стандартыг удирдлага болгон Монгол Улсын Их Хурлын сонгуулийн тухай хууль, Төсвийн тогтвортой байдлын тухай хууль, Хөгжлийн бодлого, төлөвлөлт, түүний удирдлагын тухай хууль болон Монгол Улсын Үндэсний аюулгүй байдлын үзэл баримтлал, "Алсын хараа-2050" Монгол Улсын урт хугацааны хөгжлийн бодлого, УИХ-аас баталсан хөгжлийн бодлого, төлөвлөлтийн баримт бичиг, Монгол Улсын нэгдсэн төсвийн 2024 оны төсвийн хүрээний мэдэгдэл, 2025-2026 оны төсвийн төсөөллийн тухай хууль, холбогдох байгууллагаас авсан тайлан, судалгаа, мэдээллийг тус тус шалгуур болгон авч үзсэн.

## Дүгнэлт


“Ардчилсан нам”-ын Сэврэй сумын иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2024 оны ээлжит сонгуульд оролцохоор ирүүлсэн сонгуулийн мөрийн хөтөлбөрийн зорилт, арга хэмжээ нь Аймаг, нийслэл, сум, дүүргийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын ээлжит сонгуулийн тухай хуулийн 37 дугаар зүйлийн 37.3 дахь хэсэг, Хөгжлийн бодлого, төлөвлөлт, түүний удирдлагын тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.3 дахь хэсэг, Төсвийн тогтвортой байдлын тухай хуульд заасан тусгай шаардлагад тус тус нийцсэн байна.

“Ардчилсан нам”-ын мөрийн хөтөлбөр (... хуудас)-ийг хавсаргав.

Хувийг: Сэврэй сумын Ардчилсан намын хороонд

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР

Ц.ӨСӨХБАЯР





СЭВРЭЙ СУМЫН АРДЧИЛСАН НАМААС ДЭВШҮҮЛЖ БУЙ  
ИРГЭН БҮРИЙГ ЭРХ ЧӨЛӨӨТЭЙ, ЭХ ОРОНТОЙ,  
ЭРҮҮЛ ЧИЙРЭГ, ЭРДЭМ МЭДЛЭГТЭЙ, ЭЛБЭГ БАЯН  
БАЙЛГАХ ӨМНӨГОВЬ НУТГИЙН ХИШИГ-2028  
**ХӨТӨЛБӨР**

X

## Эдийн засгийн өсөлтийн зорилго, зорилт

Мэдлэгийн эдийн засаг, технологийн дэвшил, ногоон хөгжил болон уул уурхайд түшиглэсэн хөдөө аж ахуй, аялал жуулчлал, тээвэр логистик, палеонтологи, архиелоги, экологи, үйлдвэрлэлийн салбарыг хөгжүүлж, тогтвортой эдийн засгийн өсөлтийг бий болгоно.

- Зорилт 1.** Иргэдийн ажлын байрыг нэмэгдүүлэн, өрхийн орлогыг өсгөх замаар оролцоотой эдийн засгийг хөгжүүлж, дундаж давхаргыг тэлнэ.
- Зорилт 2.** Мэдлэг, өртөг шингэсэн, өрсөлдөх чадвартай бүтээгдэхүүн үйлдвэрлэх, үйлчилгээ эрхлэх орчин бүрдүүлж, экспортод гаргахад дэмжлэг үзүүлнэ.
- Зорилт 3.** Сумын эдийн засгийг уул уурхайгаас гадна эрчимжсэн хөдөө аж ахуй, аялал жуулчлал, тээвэр логистик боловсрол, шинжлэх ухаан технологи зэрэг олон тулгуурт бүтэцтэй болгоно.
- Зорилт 4.** Сумын зөвлөн, хатуу дэд бүтцийг хөгжүүлэх замаар аймгийн бизнесийн орчинг сайжруулж, өрсөлдөх чадвартай хувийн хэвшлийг бий болгоно.
- Зорилт 5.** Төрийн болон хувийн секторын цахим шилжилтийг түргэтгэх замаар үр өгөөжийг нэмэгдүүлж, өрсөлдөх чадварыг сайжруулна.

4617144456  
КУА0068 9047824

## ХӨТӨЛБӨР, АРГА ХЭМЖЭЭ

Эдийн засгийн хүртээмжтэй өсөлт, зузаан дундаж давхарга

- Сэврэй сумын иргэдийг ажлын байраар хангах, өрхийн орлого нэмэгдүүлэх зорилгоор “Өсөлтийг Өрх Бүрд” хөтөлбөрийг хэрэгжүүлнэ.
- Малчдын орлогыг нэмэгдүүлэх, малаас авах ашиг шимийг нэмэгдүүлэх, улирлын нөлөөнөөс бага хамааралтай зорилготой “Чинээлэг малчин” хөтөлбөр хэрэгжүүлнэ.
- Малчдын нийгмийн асуудлыг шийдвэрлэх, хөдөлмөрийг хөнгөвчлөх, бэлчээрийг усжуулах, бэлчээр ашиглалтыг сайжруулах, малчдын ундны усыг эрүүл ахуйн стандарт нийцүүлэх, малжуулах чиглэсэн хөтөлбөр хэрэгжүүлнэ.
- “Нутгийн үйлдвэрлэгч” хөтөлбөрийг хэрэгжүүлж сумын бизнес эрхлэгч аж ахуйн нэгжийг өрсөлдөх чадвартай болгох, санхүү, хөрөнгө оруулалтын орон нутгийн эх үүсвэртэй болгоно.
- Дэлхийн аялал жуулчлалын байгууллагын “Аялал жуулчлалыг – Бүх нийтэд” уриалгыг хэрэгжүүлж Орон нутгийн иргэдийн аялал жуулчлалаас хүртэх ашиг орлогыг нэмэгдүүлнэ.
- Залуучууд, гарааны бизнес эрхлэгчдийн ажлын байр, санхүү, хөрөнгө оруулалт,

- технологи, инновацыг дэмжих бодлогын цогц хөтөлбөр хэрэгжүүлнэ.
7. Говь нутгийн онцлогийн шингээсэн соёлын бүтээлч үйлдвэрлэлийг аялал жуулчлалтай хослуулан хөгжүүлж, чөлөөт уран бүтээлчдийг дэмжих замаар соёлын үйлдвэрлэлийг нэмэгдүүлнэ.
  8. Сумын төвийн гэр хорооллыг иргэдийн оролцоотой дахин төлөвлөлтийг хэрэгжүүлэх зорилгоор “Шинэ хороолол” хөтөлбөрийг хэрэгжүүлнэ.
  9. Суманд “Шинэ Мянган Айл” орон сууцны хөтөлбөр хэрэгжүүлнэ. Хөтөлбөрийн хүрээнд залуу гэр бүл, төрийн албан хаагч, эмч, багш, хууль хүчиний байгууллага, цэргийн хүрээний ажилтан, албан хаагчдыг орон сууцны нөхцөлийг сайжруулах бодлого хэрэгжүүлнэ.
  10. Сумын айл бүр, алслагдсан нутгийн иргэд, төрийн байгууллагын ажилтан албан хаагчдыг өндөр хурдны интернэтийн сүлжээнд бүрэн холбоно.
  11. Мэдээлэл харилцаа холбооны шинэ техник, аж үйлдвэрийн IV, Инновацын 2.0 эрин үеийн технологийн дэвшлийг бүх шатанд ашиглалтыг нэмэгдүүлэх зорилготой “Цахим Сэврэй” хөтөлбөр хэрэгжүүлнэ.
  12. Нар, салхины зэрэг сэргээгдэх эрчим хүчиний эх үүсвэрийг ашиглан, эрчим хүчиний дотоодын хэрэгцээг хангах улмаар экспортыг бодлогоор дэмжинэ.
  13. Сумын төвийн газрын цэвэр ус, бохир ус, дулааны шугамд айл өрхийг холбох ажлыг нэмэгдүүлэх бодлого хэрэгжүүлнэ.
  14. Сумын хэмжээнд иргэн, аж ахуйн нэгжийн бизнес эрхлэхтэй холбоотой хяналт, шалгалтыг давхардуулахгүй, төрийн ямар нэгэн дарамт үзүүлэхгүй байх бодлого хэрэгжүүлнэ.
  15. Хонгорын гол орчмын аялал жуулчлалын бүс нутгийг Сэврэй сумын төвөөс өндөр хүчдэлийн цахилгааны шугамд холбоно.
  16. Хонгорын гол орчмын аялал жуулчлалын бүс нутгийг Сэврэй сумын төвөөр дамжуулан авто замаар холбоно.
  17. Даланзадгадаас Гурвантэс, Сэврэй, Ноён чиглэлийн хатуу хучилттай автозамын дагуу жуулчид, зорчигчдод зориулсан үйлчилгээний хэсгийн дэд бүтэц, ариун цэврийн байгууламж, зам талбайг байгуулна.
  18. Баруун бүсийн уул уурхайнуудад нийлүүлж болох нэг бүтээгдэхүүн нийлүүлэх үйлдвэр байгуулах ажлын байр нэмэгдүүлнэ.
  19. Сайн үүлдрийн эрчимжсэн мал аж ахуй хөгжүүлэхийг дэмжинэ.
  20. Суманд 50 дээш тонн хөргүүртэй мах ногооны зоорь бүхий мал нядалгааны газар барьж байгуулна.
  21. Сэврэй суманд 300-аас дээш хүний суудалтай Соёлын төвийн шинэ барилгыг барьж ашиглалтад оруулна.
  22. Сэврэй сумын төвийн усан хангамж, ариутгах татуургын шинэ эх үүсвэр бий болгоно.

И

## Боловсролын салбарын зорилго, зорилт

Иргэд, хүүхэд, залуус олон талт боловсролыг хүртээмжтэй олох нөхцөлийг бүрдүүлэн, тэдний гэр бүл, сургуулийн орчинд зөв төлөвшил, хүмүүжил, сурах арга барил эзэмшүүлэх замаар аль ч орны хөдөлмөрийн зах зээл дээр өрсөлдөх чадвартай мэргэжилтэн бэлтгэх

- Зорилт 1.** Цэцэрлэг, сургуулийн хамран сургалтыг зохих түвшинд байлгаж, хүүхэд, залуусын сурах бүтээлч орчинг бүрдүүлнэ.
- Зорилт 2.** Багшийн ажиллах, амьдрах орчинг сайжруулах бодлого хэрэгжүүлэх замаар багш, боловсролын салбарт ажиллагчдад мэдлэг ур чадвар, заах аргазүйгээ тасралтгүй хөгжүүлэн ахиулах нөхцөл бий болгоно.
- Зорилт 3.** Жил бүр гадаад, дотоодын шилдэг их сургуульд сурах оюутны тоог нэмэгдүүлэх бодлого баримтална. Тус бодлогын хүрээнд боломжит их сургуультай хамтарсан тэтгэлгийн сан байгуулах бодлого хэрэгжүүлнэ.
- Зорилт 4.** Сурагч, залуус, иргэдийг Өмнөговь аймгийн хөдөлмөрийн зах зээлийн эрэлтэд нийцсэн, өөрийн дур сонирхолтой мэргэжлээр сурах боломжийг бүрдүүлнэ.
- Зорилт 5.** Мэргэжил сургалт үйлдвэрлэлийн төвүүдийг шинээр байгуулж, шинэ төрлийн мэргэжил эзэмших ангиудыг нээж, хэрэгцээт мэргэжлээр суралцахыг бодлогоор дэмжинэ.
- Зорилт 6.** Бүх насны иргэд байнга сурч боловсрох, шинэ мэргэжил, ур чадвар эзэмших, тасралтгүй өөрийгөө хөгжүүлэх боломжоор хангана.

### ХӨТӨЛБӨР, АРГА ХЭМЖЭЭ

23. Сумын харьят, ажиллаж буй багш нарыг гадаадад сурах, мэргэжил дээшлүүлэх боломжоор хангах зорилгоор "Чадварлаг багш" хөтөлбөрийг үргэлжлүүлэн хэрэгжүүлнэ.
24. Орон нутагтаа тогтвортой суурьшилтай, амжилттай ажиллаж байгаа төрийн албан хаагч, иргэдийг гадаад оронд туршлага судлуулах, мэргэшүүлэх "Хөгжлийн гүүр" хөтөлбөрийг үргэлжлүүлэн хэрэгжүүлнэ.
25. Өмнөговийн харьят болон чадварлаг мэргэжилтнүүд аймаг, орон нутагтаа ирж ажиллахыг бодлогоор дэмжин "Эзэмшсэн мэргэжлээрээ эх нутагтаа ажиллая" хөтөлбөрийг үргэлжлүүлэн хэрэгжүүлнэ.
26. Суралцахуйн бэрхшээлтэй хүүхэдтэй ажиллах аргазүйд суралцах, тусгай хэрэгцээт боловсролын чиглэлээр мэргэших хүснэлтэй сургуулийн өмнөх болон бага боловсролын багш боловсон хүчнийг дэмжих замаар хүүхэд бүрийг боловсролд тэгш хамруулах нөхцөлийг сайжруулна.
27. Суралцахуйн болон оюуны бэрхшээлтэй хүүхдэд тусlamж дэмжлэг үзүүлэх сайн

- дүрүнханд орон нутгаас урамшуулалт олгох тогтолцоо бүрдүүлж, "Туслах багш – Сүүдэр багш" хөтөлбөрийг хэрэгжүүлнэ.
28. Цэцэрлэгүүдэд "Зуны цэцэрлэг" хөтөлбөр хэрэгжүүлэхийг дэмжиж, зах зээлийн зарчмаар ажиллах чөлөөт боломжийг нээнэ. Ингэснээр асран хамгаалагчид ажил хийх, хүүхэд аюулгүй орчноор хангагдах, багш нар нэмэлт орлого олох боломжтой болно.
29. Сургалтын үйл ажиллагаа явуулдаг иргэн, байгууллага холбогдох хууль дүрмийн хүрээнд стандартад нийцсэн өдөр өнжүүлэх үйлчилгээ эрхлэхийг бодлогоор дэмжинэ.
30. Цэцэрлэг, сургууль, дотуур байрны хоолны амт, чанарыг сайжруулах, ялангуяа сумдын дотуур байрны гал тогоо, хоол бэлтгэлийн орчин нөхцөлийг сайжруулна.
31. Дунд, ахлах ангийн сурагчдыг дотоод гадаадын олон улсын сургуулиудад урт болон богино хугацаагаар суралцах боломжийг олгох зорилгоор "Сурагч солилцоо" хөтөлбөрийг үргэлжлүүлэн хэрэгжүүлнэ.
32. Элсэлтийн ерөнхий шалгалт болон олон улсын шалгалтын үнэлгээнд өндөр оноо авсан багш, сурагчдыг тэтгэн урамшуулах тогтолцоо бүрдүүлнэ.
33. Сургуулийн номын сангийн үйлчилгээг сайжруулах "Найз номын сан" хөтөлбөр хэрэгжүүлж, номын фондыг баяжуулж, үншлагын танхимын орчин нөхцөл, ялангуяа гэрэлтүүлгийг олон улсын стандартын дагуу тавьж тохижуулан, ном ариутгах төхөөрөмжөөр хангана. Мөн "Цахим номын сан" нэвтрүүлэн, ном бүртгэлийг цахимжуулах, номын санчийг чадавхжуулах, ажлын үр дүн, уншигчийн тоогоор алдаршуулах, орон нутгаас урамшуулах тогтолцоог бүрдүүлнэ.
34. Бага, дунд ангийн сурагчдыг "Үдийн хоол", ахлах ангийн сурагчдыг "Үдийн цай" хөтөлбөрт хамруулж, идэвхтэй суралцах үйл ажиллагааг дэмжин, хоол тэжээлийн хомсдолд орох, хodoодны өвчлөлөөс сэргийлнэ.
35. Бага ангийн багш, сувилагч зэрэг орон нутагт нэн тулгамдаж буй боловсрол, эрүүл мэндийн салбарын мэргэжлийн боловсон хүчний хангамжийг нэмэгдүүлэхэд чиглүүлэн "Цалинтай оюутан" хөтөлбөр хэрэгжүүлнэ.
36. Жил бүр гадаад, дотоодын шилдэг их сургуульд урт богино хугацаагаар суралцах оюутны тоог нэмэгдүүлж, боломжит их дээд сургуультай "Оюутан солилцоо" хөтөлбөр хэрэгжүүлнэ. Мөн орон нутагтаа "Олон улсын боловсролын яармаг" тогтмол зохион байгуулж, гадаадад суралцах зөвлөгөө, мэдээлэл өгөх үйлчилгээг дэмжинэ.
37. Үндэсний болон олон улсын шалгалт үнэлгээ, уралдаан, тэмцээн, олимпиадад өндөр оноо авсан, амжилт гаргасан багш, оюутныг урамшуулдаг тогтолцоотой бүрдүүлж, хөшүүргийг оновчтой болгоно.
38. Малын эмч, малзүйч, ойн инженер, агрономич зэрэг мэргэжлээр нас харгалзахгүй суралцахыг бодлогоор дэмжиж, хөдөө аж ахуйн салбарт дутагдаж байгаа хүний нөөцийн асуудлыг шийдвэрлэнэ.
39. Хүүхэд, залуус, иргэд, олон нийтэд зориулсан сургалт, судалгаа, солилцоо явуулдаг орон нутагт бүртгэлтэй аливаа боловсролын байгууллага, иргэний санаачилга, ашгийн болон ашгийн бус үйл ажиллагааг дэмжих нээлттэй бодлого хэрэгжүүлнэ.
40. Үндэсний болон бусад орон нутгийн онцлогтой спортыг хөгжүүлэх хөтөлбөр

хэрэгжүүлж, сумдын хүн амын өсөлт, хөгжлийн хэрэгцээнд тулгуурлан спорт заал, спорт талбай, спорт цогцолбор барьж байгуулах, тоног төхөөрөмжөөр хангах, бүх нийтийн биеийн тамир, спортыг хөгжүүлэх орчинг бүрдүүлнэ.

41. Бүх салбарын цахим шилжилтийг түргэтгэхийн тулд “Цахим Сэврэй” хөтөлбөрийг үргэлжлүүлэн хэрэгжүүлж, бүх нийтийн цахим хэрэглээний ур чадвар, цахим орчин дахь мэдээллийн аюулгүй байдал, харилцаа хандлагыг дээшлүүлэх ажлыг зохион байгуулна.
42. Хүүхэд, залууст зориулсан компьютер программчлал, инженерчлэл, математик, мэдээлэл зүй, роботикс, техник загвар, кодингийн сургалтын хөтөлбөр хэрэгжүүлэгч байгууллага, иргэдийг дэмжих бодлого баримталж, суманд STEM сургалтын төвүүдийг байгуулна.
43. Математик, физик болон байгалийн шинжлэх ухааны багш нарыг STEM боловсролын чиглэлд чадавхжуулах, олон улсын туршлага судлах, сургалтын шинэ аргазүй нэвтрүүлэхэд нь дэмжлэг үзүүлэх зорилтот хөтөлбөр хэрэгжүүлнэ.
44. Сумын номын сангийн хөгжлийг шинэ түвшинд гаргах зорилгоор “Нутгийн номын сан” хөтөлбөр хэрэгжүүлнэ. Номын санчийг чадваржуулах, ном бүртгэлийн дэвшилтэт программ ашиглах нөхцөлийг сайжруулах, уншлагын танхимыг тохижуулах, номын фондыг өргөжүүлж, найдвартай интернэт сүлжээгээр хангах, “Цахим номын сан” ашиглах боломж нээх, номын сангийн үйлчилгээг хүртээмжтэй болгох, уншигчийн тоогоо нэмэгдүүлсэн номын санчийг урамшуулах тогтолцоо бий болгоно. Бүх нийтийн эрүүл мэндийн боловсрол, өсвөр насныхны бэлгийн боловсрол, залуучуудын гэр бүл төлөвлөлтөд чиглэсэн сургалтуудыг дэмжинэ.
45. Хүүхэд, залуус, иргэдийн урлаг, спорт, гоо зүйн боловсролыг дэмжих хөтөлбөр хэрэгжүүлнэ.
46. Бүх нийтийн эрүүл мэндийн боловсрол, өсвөр насныхны бэлгийн боловсрол, залуучуудын гэр бүл төлөвлөлтөд чиглэсэн сургалтуудыг дэмжинэ.
47. Бүх нийтийн монгол уламжлал, ёс заншил, байгаль, экологийн боловсролыг дээшлүүлэх зорилтот хөтөлбөр хэрэгжүүлнэ.
48. Бүх нийтийн англи хэлний боловсролыг дээшлүүлэх чиглэлд үйл ажиллагаа явуулж буй иргэний санаачилга, байгууллагыг гаргасан амжилт, үр дүнд нь суурилан урамшуулдаг тогтолцоог бий болгоно.
49. Бүх нийтийн хууль эрх зүйн мэдлэгийг дээшлүүлж, Монгол Улсын Үндсэн хуулийн үзэл санааг түгээн дэлгэрүүлэх хөтөлбөр хэрэгжүүлнэ.
50. Бүх нийтийн санхүүгийн боловсролыг дээшлүүлэх хөтөлбөр хэрэгжүүлнэ. Мөн бүх нийтэд зориулсан төслийн менежментийн сургалт, насанд хүрэгчдэд зориулан нягтлан бодох бүртгэлийн эчнээ сургалт зэргийг орон нутагтаа зохион байгуулахыг бодлогоор дэмжинэ.
51. Малчид, өрхийн үйлдвэрлэл, хувийн бизнес эрхлэгчид, гарааны аж ахуйн нэгжүүдийг чадавхжуулах, өрсөлдөх чадамжийг нэмэгдүүлэхэд чиглэсэн ур чадварын сургалтуудыг тогтмол явуулах, гадаад дотоодод туршлага судлахад нь дэмжлэг үзүүлэх зорилтот хөтөлбөр хэрэгжүүлнэ.

Ш

## Засаглалын хөгжлийн зорилго, зорилт

Хувь хүний халдашгүй байдал, хууль ёсны эрх, ашгаа хамгаалуулах, шударгаар шийдвэрлүүлэх, гэм буруутай нь шүүхээр тогтоогдоогүй байхад ял зэм хүртэхгүй, хуулиас гадуур мөрдөн шалгагдахгүй байх, ялгаварлал, хүчирхийллээс ангид, айдасгүй амьдрах нөхцөлийг бүрдүүлнэ

- Зорилт 1.** Хүний эрхийг дээдэлсэн, иргэдийн оролцоог хангасан, ил тод, ёс зүйтэй, шуурхай төрийн үйлчилгээг оновчтой бодлогоор удирдана.
- Зорилт 2.** Төрийн үйлчилгээний чанар, хүртээмжийг сайжруулж, авлига, хүнд сурталгүй, иргэдийн эрэлтийг хангасан үйлчилгээг бий болгоно.
- Зорилт 3.** Сумын бүх шатны удирдлага иргэдийн оролцоотой шийдвэр гаргадаг, тэр шийдвэр нь ил тод, шуурхай хүртээмжтэйгээр иргэдэд хүргэдэг болно.
- Зорилт 4.** Орон нутгийн иргэдийн тэгш оролцоог хангаж, аливаа хэлбэрийн ялгаварлан гадуурхах байдлыг устгана.
- Зорилт 5.** Ил тод, нээлттэй байдал, иргэдийн оролцоог хангах зорилгоор “Цахим засаглал” бий болгоно.
- Зорилт 6.** Хүний эрх, иргэний оролцоо<sup>56</sup> өөрийн зохицуулалтын чиглэлд үйл ажиллагаа явуулдаг төрийн бус байгууллага, сайн дурын үйл

## ХӨТӨЛБӨР, АРГА ХЭМЖЭЭ

52. Сумын иргэдийн төлөөлөгчдийн хурлын үйл ажиллагаанд иргэд олон нийтийн оролцоо, хяналтыг сайжруулна. Сумын ИТХ-ын төлөөлөгчид болон иргэд, сонгогчдын эргэх холбоог нэмэгдүүлнэ.
53. Иргэн цахим санаачилга гаргасан, иргэд цахимаар гарын үсэг цуглуулж тодорхой асуудлыг дэвшүүлсэн тохиолдолд аймаг, сумын ИТХ шууд авч хэлэлцэх журам тогтооно.
54. Төрийн үйлчилгээний чанар, хүртээмжийг сайжруулах, үйл ажиллагааны ил тод байдлыг нэмэгдүүлэх, шийдвэр гаргах үйл ажиллагаанд иргэдийн оролцоог нэмэгдүүлнэ.
55. Нутгийн өөрөө удирдах ёс болон төрийн захиргааны байгууллагын гаргасан бодлого, шийдвэрийн үр нөлөөг бодлогын судалгааны хүрээлэнгээр дамжуулан үнэлдэг болгоно.
56. Ил тод, нээлттэй байдал, иргэдийн оролцоог хангах зорилгоор Цахим засаглал бий болгоно.
57. Цахим орчны эрх зүйн харилцааг боловсронгуй болгох, цахим орчинд хүний нэр

төр, ажил хэргийн нэр хүндийг хамгаалах, байгууллага, хувийн мэдээлэл, нууц, өгөгдлийн аюулгүй байдлыг хангана.

58. Төрийн үйл ажиллагаа, төсвийн зарцуулалт, төрийн өмчтэй аж ахуйн нэгжүүдэд тавих иргэний болон хөндлөнгийн хяналтыг нэмэгдүүлнэ.
59. Төрийн албаны мерит зарчмыг хадгална.

## И

## Эрүүл мэндийн салбарын зорилт, зорилт

Сумын хүн бүрийн эрүүл мэндийг хамгаалах, аливаа өвчлөлөөс урьдчилан сэргийлэх, өвчнийг оношлох, эрүүл дадал хэвшилтэй, идэвхитэй амьдралын хэв маягтай иргэн улмаар эмчлэх замаар дундаж наслалтыг нэмэгдүүлэхэд оршино

- Зорилт 1.** Хүн амыг аливаа өвчлөлөөс урьдчилан сэргийлж, өвчнийг эрт илрүүлэх бодлогыг хэрэгжүүлнэ.
- Зорилт 2.** Эмнэлгүүдийн чанар, хүртээмжийг нэмэгдүүлнэ. Бүсийн эмчилгээ, оношилгооны төвийн үйлчилгээг иргэдийн хэрэгцээ, шаардлагад нийцүүлнэ.
- Зорилт 3.** Иргэдийг эрүүл дадал хэвшил, амьдралын идэвхтэй хэв маягт уриалсан бодлого хэрэгжүүлнэ.
- Зорилт 4.** Хөгжлийн бэрхшээлтэй иргэд идэвхтэй сурч, хөдөлмөрлөх, орлогоо нэмэгдүүлж, нийгмийн харилцаанд ороход тэгш, хүртээмжтэй, тогтвортой нөхцөлийг бүрдүүлнэ.
- Зорилт 5.** Эмч, сувилагч, эрүүл мэндийн салбарын мэргэжилтний тоо, хүрэлцээг нэмэгдүүлнэ. Тэдний амьдрах орчин, нийгмийн хамгааллыг сайжруулна.

## ХӨТӨЛБӨР, АРГА ХЭМЖЭЭ


60. Иргэн бүр эрүүл мэндийн байгууллагаас чанартай, соёлтой үйлчилгээ хүртэхэд чиглэсэн зорилтот хөтөлбөр хэрэгжүүлнэ. Ингэхдээ эмч, сувилагч, эмнэлгийн мэргэжилтнүүдийн тоог нэмэгдүүлэх, эмнэлгүүдийг өргөтгөх болон шинээр эмнэлэг барих бодлого баримтална.
61. Иргэн бүрийг өвчнөөс урьдчилан сэргийлэх, эрт илрүүлэх үзлэг, оношилгоо, шинжилгээнд тогтмол хамрагдахыг дэмжсэн бодлого хэрэгжүүлнэ. Эрт илрүүлгийн нэгдсэн төв, оношилгооны иж бүрэн лабораторийг байгуулж, үйл ажиллагааг жигдруулнэ.
62. Хүн амын эрүүл чийрэг байхад зориулагдсан спорт заал, бялдаржуулах төвүүдийг нэмэгдүүлнэ.

63. “Эрүүл элэг”, “Эрүүл шүд” хөтөлбөрийг үргэлжлүүлэн хэрэгжүүлэх, хавдрын химиин эмчилгээний чанар хүртээмжийг нэмэгдүүлнэ.
64. Өсвөр насыхан болон насанд хүрэгчдэд нөхөн үржихүйн эрүүл мэнд, бэлгийн боловсрол олгох цогц нөлөөллийн ажил явуулах, өвчнөөс урьдчилан сэргийлэх үзлэгт хамрагдах, эрт оношуулах, эмчлүүлэх ач холбогдолтой талаар олон нийтэд зөв ойлголт өгөх, оношилгоо, эмчилгээ, нөхөн үржихүйн асуудлаарх олон нийтийн хүний эрхийн мэдрэмжийг дээшлүүлнэ.
65. Хүүхэд залуусын сэтгэцийн эрүүл мэндийг хамгаалах, архи, тамхи болон цахим тоглоом, видео контентод донтох, сэтгэцэд нөлөөлөх бодист мансуурах зэрэг эрсдэлээс урьдчилан сэргийлэх зорилтот хөтөлбөр хэрэгжүүлнэ. Нойрны дутагдлаас үүссэн мэдрэлийн ядаргаа, сэтгэл түгшилт, сэтгэл гутралаас сэргийлэх, уур бухимдал тайлах идэвхтэй аргуудыг сурч, сэтгэл хөдлөлийн ур чадваруудыг эзэмшихэд нь дэмжлэг үзүүлэх үйлчилгээ нэвтрүүлнэ.
66. Хувийн хөрөнгө оруулалтаар спорт, бялдаржуулах клуб, эрүүл зөв амьдралын хэв маягийг ард иргэдэд хэвшүүлэх зорилго бүхий үйл ажиллагааг бодлогоор дэмжинэ.
67. Эх хүүхдийн эрүүл мэнд хөтөлбөрийг боловсронгуй болгож, эх хүүхдийн хоол тэжээлд дэмжлэг үзүүлэх “Сүү тараг” хөтөлбөрийг үргэлжлүүлэн хэрэгжүүлнэ.
68. Агаарын бохирдол, тоосжилт, хөрсний бохирдол, хорт ургамлаас шалтгаалсан харшлын өвчлөлийг бууруулах, урьдчилан сэргийлэх зорилгоор “Харшлын эсрэг тэмцье” хөтөлбөрийг хэрэгжүүлнэ.
69. Иргэдийн хүнсний бүтээгдэхүүнээ зөв сонгох, аюулгүй хүнс хэрэглэхийн ач холбогдол болон хүний эрүүл мэндэд сөрөг нөлөө үзүүлэх бүтээгдэхүүн, үйлчилгээнээс татгалзах зан үйлийг дэмжинэ.
70. Хүнсний хувьсгал үндэсний хөдөлгөөнийг аймгийн хэмжээнд өрнүүлж, Хүнсний хангамж-аюулгүй байдлын төлөвлөгөөг хэрэгжүүлэхийн зэрэгцээ хүнсний хяналт шалгалтыг боловсронгуй болгоно.
71. Хүн амыг стратегийн эрүүл, аюулгүй хүнсээр хангах ажлын хүрээнд эрүүл ахуй, стандартын шаардлага хангасан мал нядалгааны газрыг сумдын төвүүдэд байгуулна.
72. Гэр бүл болон иргэд хамтран нийгэмд хорших маягаар хөдөлмөрлөх, өөрийгөө хөгжүүлэх санал санаачилгыг дэмжинэ.
73. Ахмадын амралт сувиллын газар, хоол тэжээлийн төвийг суманд байгуулна. Ахмад настны хөгжил, хамгааллын үйлчилгээг сайжруулах зорилгоор зарим сумдад ахмадын хөгжлийн өргөөг сумдад байгуулна.

Г

## Байгаль орчны салбарын зорилго, зорилт

Говь цөлийн бүсийн экологийн тэнцвэрийг хангах, хүрээлэн буй орчны унаган төрхийг хэвээр хадгалан үлдээх, хүний буруутай үйл ажиллагаа, уул уурхайн хайгуул, олборлолт, тээвэрлэлт, үйлдвэрлэлээс байгаль үзүүлэх сөрөг нөлөөллөөс урьдчилан сэргийлэх, байгаль орчны хэтийн бодлогын удирдлагыг орон нутгийн түвшинд оновчтой төлөвлөх, хэрэгжүүлэх.

- Зорилт 1.** Иргэд, олон нийт, төрийн бус байгууллагын оролцоотойгоор байгаль хамгаалах, хүрээлэн буй орчны бохирдлыг бууруулах төсөл, хөтөлбөр, нөлөөллийн ажлыг төлөвлөн хэрэгжүүлнэ.
- Зорилт 2.** Агаар, хөрс, ус, гэрлийн бохирдлыг зөвшөөрөгдөх хэмжээнд хүргэх буюу хадгална. Гэр хорооллоос үүдэлтэй орчныг бохирдлыг бууруулна. Хуурай технологийн жорлонг байгуулна.
- Зорилт 3.** Байгаль орчинд хохирол учруулсан аливаа хуулийн этгээд, иргэнд зохих хариуцлагыг хүлээлгэж хохирол барагдуулах механизмыг боловсронгуй болгоно.
- Зорилт 4.** Уул уурхайгаас үүдэлтэй байгаль орчны бохирдлуудыг бууруулна. Хууль бус лицензийг цуцалж, эвдэгдээгүй газар нутгийг унаган төрхөөр нь хадгалан хамгаалж, аялал жуулчлалын шинэ зорих газрыг бий болгоно.
- Зорилт 5.** Сумын нийт газар нутаг, төв суурин газрын ногоон байгууламжийг нэмэгдүүлнэ. 
- Зорилт 6.** Биологийн олон янз байдал, тэр дундаа ховордож буй амьтан, ургамлыг хамгаална. Байгалийн өвт газруудын хамгаалал, ашиглалтыг орон нутгийн иргэдийн оролцоонд тулгуурлан хэрэгжүүлнэ.
- Зорилт 7.** Байгаль орчинд халгүй технологи нэвтрүүлэхэд шаардлагатай санхүүгийн хөшүүрэг бий болгож, энэ чиглэлд төр-хувийн хэвшлийн хамтын ажиллагааг дэмжинэ.

### ХӨТӨЛБӨР, АРГА ХЭМЖЭЭ

74. Зэрлэг амьтны усны эх үүсвэрийг нэмэгдүүлж, бага гүний худаг гаргах, дарагдсан булаг, худгийг сэргээнэ.
75. Тусгай хамгаалалттай газар нутгийн менежментийг сайжруулахад олон улсын ба мэргэжлийн байгууллага, орон нутгийн төсвийн орлогыг нэмэгдүүлнэ. Ийм газрын тодорхой хэсгийг нутгийн иргэдийн бүлэг, нөхөрлөлд менежментийн гэрээгээр ашиглуулах бодлого хэрэгжүүлнэ.
76. Зэрлэг амьтан судлах хамгаалах тусгай сонирхлын аяллыг хөгжүүлэх зорилгоор алслагдсан, говь цөлийн бүс газар нутгуудад зэрлэг амьтад, нүүдлийн зүйлүүдэд зориулсан усалгааны цэг, хөв цөөрмийг байгуулж, Экологийн коридор – Холбоос нутгийг байгуулна.
77. Орон нутгийн иргэдийн Байгаль хамгаалах нөхөрлөл, ТББ-ыг хөхиулэн дэмжиж

байгаль хамгааллын үр шимийг хүртэх боломжийг бий болгоно.

78. "Хашаандаа сайхан амьдарцгаая" аяныг өрнүүлж иргэдийг хашаандаа ая тухтай сайхан амьдрах дэд бүтцээр хангана. Аймгийн хэмжээнд иргэн, аж ахуйн нэгжийн ашигт ургамал, жимс жимсгэнэ, алим тариалалтыг нэмэгдүүлэх хөтөлбөр хэрэгжүүлнэ.
79. Агаарын бохирдол, хөрсний бохирдол, экологийн хүчин зүйлийн зэрэг байгаль орчны үзүүлэлтүүдийг тогтмол хэмжиж, үр дүнг дүгнэж байна.
80. Задгай булаг шанд, баян бүрд, горхи, гадаргад ойрхон уст цэгүүдийг дайруулан ногоон бус байгуулах иргэд, аж ахуйн нэгжийн санал санаачилгыг дэмжинэ.
81. Сумын усны нөөц, чанарын, хяналтын нэгжийн үйл ажиллагааг бэхжүүлж, газар нутгийн усны судалгаа, шинжилгээ, ашиглалт, хамгаалалтын тогтолцоог боловсронгуй болгоно.
82. Сумын газар тариалан, ногоон байгууламж, таримал ойн сангийн усны эх үүсвэрт зориулан хөв цөөрөм, гадарлын усаар гүний усыг арвижуулах төсөл, газрын доорх далан байгуулах төслүүдийг хэрэгжүүлнэ.
83. Сумын төвийн ногоон байгууламжийг ус хангамжийн нэгдсэн, найдвартай эх үүсвэрт холбоно.
84. Хүрээлэн буй орчныг хамгаалах, байгальд ээлтэй шинэ технологи, үйлдвэрлэлийг бий болгож үр ашигтай ажлыг тууштай дэмжин ажиллана.
85. Өмнөговь аймгийн экосистем, зэрлэг байгалийн танин мэдэхүйн сурх бичиг, хичээлийн хөтөлбөр бий болгоно. Байгал хамгаалах сайн дурын клуб, хүүхдийн клуб, төрийн бус байгууллагын үйл ажиллагааг дэмжин хөгжүүлнэ.
86. Говь цөлийн экосистем, биологийн олон янз байдал, экосистемд үзүүлдэг хүний буруутай үйлдлийн сурагчид, залуучууд, иргэдийн мэдлэгийг нэмэгдүүлнэ.